

# МОНОС ХҮНС ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 08-р сарын 08-ны өдөр

№ 13/08

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнийг түр орлох этгээд томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5, 77.6 дахь заалт, 79 дүгээр зүйл, 81 дүгээр зүйлийн 81.5 дахь заалт, “Монос Хүнс” ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.17.1, 7.17.2 дахь заалт болон 2023 оны 08 сарын 08-ны өдрийн ТУЗ-ийн хурлын шийдвэр, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос гаргасан саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлох этгээдээр Дашцэрэн овогтой Энхтүвшинг томилсугай.
2. Д.Энхтүвшин нь компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүний эрхийг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс эхлэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудлыг хэлэлцэх хүртэл хугацаанд эдлэхийг дурдсугай.
3. ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Энхтүвшинг чөлөөлөгдсөн хараат бус гишүүний томилгооны оронд буюу ТУЗ-ийн дэргэдэх Стратеги, бизнес хөгжлийн хорооны даргаар, Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны гишүүнээр тус тус томилж, Монгол улсын хууль тогтоомж, компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн хурлын дэг болон бусад холбогдох компанийн засаглалын эрх зүйн баримт бичгийг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
4. ТУЗ-ийн хараат бус гишүүн томилогдсон тухай мэдээллийг холбогдох журамд заасны дагуу эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Н.Цагаанхүү/, олон нийтэд мэдээлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /А.Отгондарь/ нарт үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Х.АНАНД